

2007 ОНЫ 12 ДУГААР САРЫН 21-НЭЭС ЧЕХ УЛС ШЕНГЕНИЙ БҮСД НЭГДСЭНЭЭР ДАРААХ БОДИТ ӨӨРЧЛӨЛТҮҮД ГАРЛАА:

- Чех улсын хил дээрхи хилийн шалган нэвтрүүлэх хяналтууд байхгүй болсон
- Харин эсрэгээр Шенгений бүсийн гадаад хил дээрхи хяналтыг чангатгасан. (тухайлбал, Словак-Украин, Польш-Украины хил гэх мэт)
- Хил дээрхи хяналт шалгалт нь,
 - Таны биеийн байцаалт, бичиг баримтыг шалгана.
 - Чех улсын нутаг дээр байх/оршин суух хугацааны санхүүгийн хүрэлцээтэй боломжтой эсэхийг тань тодруулна.
 - Та өөрийн байх/оршин суух шалтгаанаа хангалттай хэмжээнд батлан тайлбарлах шаардлагатай.

2007 оны 12 дугаар сарын 21-нээс Чех улс Шенгений бүсд нэгдсэнээр дараах бодит өөрчлөлтүүд гарлаа

- Шенгенийн мэдээллийн системээс таныг энэ бүсэд нэвтрүүлэхэд татгалзах шалтгаангүй эсэхийг тодруулна.
- Шенгенийн мэдээллийн систем нь цагдаагийн мэдээллийн сан бөгөөд дараахь зүйлсийг тодруулна:
 - Хил нэвтэрч байгаа гадаадын иргэн нь урд өмнө нь Шенгенийн бүсэд нэвтрэх/оршин суух эрхээ хасуулсан, хязгаарлуулсан эсэх,
 - Хувь хүн болон унаж яваа автомашин нь шалгагдах шаардлагатай эсэх,
 - Хил нэвтрэгч нь Европын цагдаагийн болон олон улсын гэрээнд заагдсан журмаар саатуулагдах/баривчлагдах эсвэл аль нэгэн улсад шилжүүлэн өгөхөөр зарлагдсан эсэх,
- Виз олголт нь удаан хугацаагаар үргэлжилж болох бөгөөд нийт виз мэдүүлэгчдэд бүгдэд нь олгогдохгүй байж болно.

ТА ЯНЗ БҮРИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ОРЖ БОЛНО

■ ТА ЧЕХ УЛСАД ХУУЛЬ БУСААР ХӨДӨЛМӨР ЭРХЭЛЖ БАЙНА УУ

- Та Чех улсын нутаг дэвсгэрт хууль ёсоор хөдөлмөр эрхлэхийн тулд хөдөлмөрийн виз (Хөдөлмөр эрхлэлтийн виз) ба ажиллах зөвшөөрөлтэй байх шаардлагатай
- Хөдөлмөрийн виз болон ажиллах зөвшөөрөл байхгүй тохиолдод Гадаадын иргэдийн цагдаагийн газар таныг Чех улсын нутаг дэвсгэрээс цаашид 5 хүртэл жилийн хугацаанд дахин нэвтрэх эрхгүйгээр албадан гаргахаар шийдвэрлэж болно.

- Хэрвээ та хууль бусаар ажиллаж байгаа бөгөөд энэ нь хүчирхийлэл болон мөлжлөгийн хэлбэртэй (таныг албадан хөдөлмөрлүүлж байгаа, хөдөлмөрийн хөлсийг тань олгохгүй байгаа, эрх чөлөөг тань хязгаарлаж байгаа, ажил олгогч тань таныг хууран мэхэлж мөлжиж байгаа эсвэл таны баримт бичгийг хураан аваад буцааж олгохгүй байгаа) бол зарим нөхцөлд таны хөдөлмөр эрхлэлтийг албан ёсны болгож болно.
- Нэмэлт мэдээллийг Ла Страда (La Strada) болон цаашид дурдагдах зарим байгууллагуудаас авч болно.

■ ЧЕХ УЛСАД ЖУУЛЧЛАЛЫН ВИЗЭЭР ИРСЭН БОЛОВЧ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХИЙГ ХҮСЧ БАЙНА УУ

- Энэ төрлийн визээр Чех улсад ирээд ажил хийхийг зөвшөөрдөггүй.
- Хэрвээ ажил хөдөлмөр эрхэлбэл, цагдаагийн газар таныг Чех улсын нутаг дэвсгэрээс цаашид 5 хүртэл жилийн хугацаанд дахин нэвтрэх эрхгүйгээр албадан гаргахаар шийдвэрлэж болно.
- Энэ төрлийн визний хүчинтэй хугацаанд Чех улсад байх үедээ ажиллах ба оршин суух зөвшөөрлийг авах шаардлагатай бэлтгэлийг хангаж болно. (Чех улсад оршин суух зөвшөөрөл/хөдөлмөр эрхлэх визийг ихэнхи тохиолдолд зөвхөн Чех улсын нутаг дэвсгэрийн гадна, Чех улсын элчин, төлөөллийн газраас олгодог!)
- Цаашид дурдагдах зарим байгууллагаас тусламж дэмжлэг хүсч болно.

■ ТА ЧЕХ УЛСАД ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ВИЗ БОЛОН АЖИЛЛАХ ЗӨВШӨӨРӨЛТЭЙГЭЭР АЖИЛЛАЖ БАЙНА УУ

- Таны ажлын зөвшөөрөл нь тодорхой нэгэн ажил олгогч ба ажлын байранд олгогдсон байх боловч нэгэн зэрэг хэд хэдэн ажлын зөвшөөрөлтэй байж болно.
- Ямар нэгэн шалтгаанаар ажлаа өөрчлөхийг хүсвэл:
 1. Шинэ ажил олгогчийг олох,
 2. Ажил олгогчийн үйлдэл нь:
 - a) Ажил олгогч нь юуны өмнө ажлын сул байрны тухай ажлын байр байрлах дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн Газар (úřadě práce - ÚP)-т мэдэгдэнэ.
 - b) Хэрэв энэхүү ажлын сул байранд чех ажилчин олдохгүй бол та энэ ажилд орж болно

3. Ажилчны (таны) үйлдэл нь:

- a) Ажил эрхлэх дүүргийн төвийн Хөдөлмөр эрхлэлтийн Газар (ÚP)-аас холбогдох маягтуудыг (хөдөлмөр эрхлэх өргөдөл ба ажил олгогчоос танд ажил олгох зөвшөөрөл) авна.
- b) Өргөдлийн маягтыг бөглөж, ажил олгогчоос танд ажил олгохыг маягт дээр баталгаажуулуулна.
- c) Өргөдөлд дараахь зүйлс хавсрагдана
 - I. Биеийн байцаалт (паспорт)-ын таны тухай мэдээллийг (овог нэр, төрсөн он сар өдөр гэх мэт) агуулсан хуудсуудын хуулбар
 - II. Тухайн ажилд та ажиллаж болохыг батлах баримтууд (жишээлбэл, эмнэлгийн сувилагчаар ажиллах бол мэргэжлийн үнэмлэх, эсвэл энэ талаархи таны ажлын туршлагыг батлах баримт) нь эх хувиараа, чех хэлнээ орчуулсан албан орчуулгын хамт

III. Ажил олгогчоос танд ажил олгох баталгаа (Хөдөлмөр эрхлэлтийн газараас олгосон маягтын дагуу)

IV. Өргөдөл хяналтын хураамж нь 500 КĚ байдаг.

- Ажлын зөвшөөрөл нь хамгийн удаандаа 2 жилийн хугацаагаар олгогдох бөгөөд цаашид сунгуулж болдог. (Сунгуулах хүсэлтээ зөвшөөрлийн хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө гаргах ёстой.)
- Та ажлаа алдвал, ажил эрхлэх зөвшөөрлөө давхар алддаг. Шинээр ажил олгогч олж болох боловч ажил эрхлэх дээр дурдсан шаардлагуудыг шинээр хангах шаардлагатай болдог (ажлын зөвшөөрлийг шинээр авахтай бараг адил) ба хөдөлмөр эрхлэлт тасралтгүй үргэлжлэх ёстой.

■ Зарим тохиолдолд шинээр ажлын байр олоход 60 хоногийн хугацаа олгогдоно. Гэхдээ энэ тохиолдол нь,

1. Анхаар! Үүний тулд Чех улсад 1 жилээс багагүй хугацаанд албан ёсоор ажилласан эсвэл тасралтгүй 3 жилээс багагүй хугацаагаар (удаан хугацаагаар амьдрах виз буюу зөвшөөрөл олгогдсоноос хойшхи хугацаагаар тооцогдоно) амьдарсан,
2. Зөвхөн орон тооны цомхтгол, эрүүл мэндийн шалтгаан эсвэл ажил олгогч танд цалин олгохгүй байсан (Хөдөлмөрийн хуулийн 52 ба 56 дугаар зүйлүүд) зэрэг шалтгаануудаар ажлаас халагдсан,
3. Энэ тухай бүх тайлбарыг бичгээр гаргах шаардлагатай. Гэхдээ энэ үйлдлийн өмнө нь таныг Ашгийн бус байгууллагын хуульчидаас (үнэгүй зөвлөлгөө өгөгдөж болох тул) зөвлөлгөө авахыг зөвлөж байна.

- Ажил олгогч нь таныг халах тухай шийдвэрээ 10 хоногийн өмнө Хөдөлмөр эрхлэлтийн газарт мэдэгдэх үүрэгтэй бөгөөд Хөдөлмөр эрхлэлтийн газар нь Гадаадын иргэдийн цагдаагийн газарт мэдэгдэнэ.
- Та ажлаас халагдаад, шинээр ажил олоогүй боловч танд оршин суух эрх олгосон энэхүү нөхцлийг зөрчин Чех улсын нутагт үргэлжлүүлэн оршин суусаар байвал таныг цагдаагийн газар албан хүчээр гаргаж болно.

ЗАРИМ ОНЦГОЙ НӨХЦЛҮҮД

■ ЧЕХ УЛСААС ОЛОН УЛСЫН ХАМГААЛАЛТ (ОРОГНОЛ) ХҮССЭН БА АЖИЛЛАХЫГ ХҮСЧ БАЙВАЛ

- Олон улсын хамгаалалт хүссэн этгээдийн хувьд өргөдөл өгсөнөөс хойш эхний 12 сарын дотор Чех улсын нутаг дээр албан ёсоор хөдөлмөр эрхлэх боломжгүй.
- 12 сарын дараа, хэрвээ танд Олон улсын хамгаалалт хийгдээгүй бол ажил олгогчийг олж ажиллах зөвшөөрөл хүсч болно. (ажилбар нь дээрхитэй адил)
 - Ажил олгогч нь Хөдөлмөр эрхлэлтийн газар сул ажлын байрны тухай зөвхөн мэдэгдэнэ.

■ **ТАНД ОЛОН УЛСЫН ХАМГААЛАЛТ ЗӨВШӨӨРӨГДСӨН (ОРОГНОЛЫН ХЭЛБЭРЭЭР) БА ТА АЖИЛЛАХЫГ ХҮСЧ БАЙВАЛ**

- Ажиллах зөвшөөрөлд мэргэжил, чадварын шаардлага тавигдахгүй
- Ажил олгогч нь танд ажил олгох тухайгаа холбогдох Хөдөлмөр эрхлэлтийн газарт урьдчилан мэдэгдэх үүрэгтэй.

■ **ТА ЧЕХ УЛСЫН НУТАГ ДЭЭР ВИЗНИЙ ХУГАЦАА ДУУСАХ ХҮРТЭЛ ОРШИН СУУЖ БАЙГАА (ГАДААДЫН ИРГЭДИЙН ОРШИН СУУХ ХУУЛИЙН ДАГУУ) БА АЖИЛЛАХЫГ ХҮСЧ БАЙВАЛ**

- Ажил эрхлэх зөвшөөрөлтэй байх ёстой (ажилбар нь дээрхитэй адил)

- Ажил олгогч нь ажлын сул байрны тухай Хөдөлмөр эрхлэлтийн газарт зөвхөн мэдэгдэх бөгөөд энэ ажилд чех ажилчин ирэхийг хүлээх шаардлагагүй.
- Та ажлаас халагдвал таны оршин суух эрхэнд өөрчлөлт орохгүй бөгөөд ажил олгогч нь зөвхөн таны халагдсаныг Хөдөлмөр эрхлэлтийн газарт мэдэгдэнэ.

■ **ЧЕХ УЛСЫН НУТАГ ДЭЭР ХАМГААЛАГДАХ ГОРИМООР УДААН ХУГАЦААНЫ ОРШИН СУУХ ЭРХТЭЙГЭЭР БАЙГАА БА АЖИЛЛАХЫГ ХҮСЧ БАЙВАЛ**

- Ажиллах зөвшөөрөлтэй байх шаардлагагүй.
- Ажил олгогч нь танд ажил олгох тухайгаа холбогдох Хөдөлмөр эрхлэлтийн газарт ажиллуулахаасаа 1-ээс доошгүй хоногийн өмнө мэдэгдэнэ.

■ **НОГООН КАРТ (2009 ОНЫ 1 ДҮГЭЭР САРЫН 1-НЭЭС ХҮЧИНТЭЙ)**

- Одоо үйлчилж байгаа виз/оршин суух журмын хүрээнд хүчин төгөлдөр байгаа.
- Ногоон карт нь амьдрах болон хөдөлмөр эрхлэх эрхийг нэгэн зэрэг олгодог.
- Ногоон карт нь зөвхөн тодорхой ажлын байруудад зориулан олгогддог.
- Картын төрлүүд: А- Дээд боловсролтой болон нарийн мэрэгжлийн хүмүүст; В - Тодорхой хэмжээнд сургагдсан хүмүүст; С - Мэрэгжил боловсролгүй ажиллах хүчинд.
- Ногоон карт нь зөвхөн дараах улсуудын иргэдэд олгогдоно. Үүнд: Австрали, Монтенегро, Хорват, Япон, Өмнөт Солонгос, Шинэ Зеланд, Босня-Герцоговина, Македони, Америкийн Нэгдсэн Улс, Серб, Украин.

- Нэмэлт болон Ногоон карт олгох ажлын байрууд, мэдүүлэх баримтын маягтуудын тухай мэдээллийг интернетийн http://portal.mpsv.cz/sz/zahr_zam/zelka хаягаас (англи, орос, франц, испани хэлүүд дээр) тодруулна уу.

ВИЗ

■ ЖУУЛЧНЫ ВИЗ (90 ХҮРТЭЛХИ ХОНОГИЙН ВИЗ)

- Визийг гадаад дахь Чех улсын төлөөллийн газраас, төлбөртэйгээр, 30 хоногийн дотор олгоно.
- Виз нь заагдсан хугацаандаа хүчин төгөлдөр бөгөөд дээд тал нь 90 хоногийн хугацаатай байна.
- Онцгой тохиолдолд визыг сунгаж болдог. (жишээ нь, Чех улсад байх хугацаандаа өвдвөл)
- Визны төрлийг өөрчлөхийн тулд визыг сунгахгүй. (жишээ нь, жуулчны визээс хөдөлмөр эрхлэх виз болгож)

■ ШЕНГЕНИЙ НЭГДСЭН ВИЗ

- Визны төрлөөс хамааран (А, В ба С) Шенгенийн бүх оронд 3 сар хүртэл хугацаагаар хүчинтэй. Үүнийг Шенгенийн зарим улсаас олгодог.
- Гадаадын иргэдээс шаардагдах нь:
 - Хил нэвтрэхэд шаардлагатай нэг буюу түүнээс дээш тооны хүчин төгөлдөр баримт бичигтэй байх;
 - Хүчин төгөлдөр визтэй байх;
 - Аяллын зорилго, байрлах нөхцөл, оршин байх хугацаа болон эх орондоо эсвэл 3-дагч улс руу буцах хүртлээ зарцуулах мөнгөн санхүүгийн чадвартай буюу үүнийг шийдвэрлэх боломжтойг баталсан баримт материалууд;
 - Хилээр нэвтрэн орохыг хязгаарласан/хориглосон этгээд биш байх;

- Нийгмийн хэв журам, улсын аюулгүй байдал, олон улсын гэрээгээр тохиролцсон улс хоорондын харьцаанд харш байдал үүсгэх нөхцөлгүй байх

■ ШЕНГЕНИЙН БҮСЭД НЭГДСЭНЭЭР ЧЕХ УЛСАД ОРШИН СУУХ ЭРХ БҮХИЙ 3-ДАГЧ ОРНЫ ИРГЭДИЙН ХУВЬД:

- Оршин суух эрх нь Чех улсын нутаг дээр хүчинтэй
- Шенгенийн бүсийн бусад оронд 3 сар хүртэл хугацаагаар хүртэл оршин байж болно.
- Гэхдээ тухайн улсын хөдөлмөр эрхлэх зорилгоор оршин суух виз/ажлын зөвшөөрөлтэй холбогдох шаардлагуудыг биелүүлсэний үндсэн дээр ажил хөдөлмөр эрхэлж болно.

■ ХӨДӨЛМӨРИЙН ВИЗ (ЧЕХ УЛСАД ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ЗОРИЛГООР 90-С ДЭЭШ ХОНОГООР ОЛГОГДСОН ВИЗ)

- Визыг гадаад дахь Чех улсын Төлөөллийн газраас Чех улсын гадаадын иргэдийн цагдаагийн газрын шийдвэр дээр үндэслэн олгогдоно.
- Виз хүссэн өргөдөлийг бэлэн маягтаар мэдүүлнэ.
- Үүнээс гадна доорхи баримтуудыг хавсаргана:
 - Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл (ажлын зөвшөөрөл); хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл хүссэн өргөдөл өгсөн даруйдаа визээ мэдүүлж болно. Энэ тохиолдолд виз хүссэн өргөдөлдөө Хөдөлмөр эрхлэлтийн газар өгсөн өргөдөлийн дугаарыг дурдана.
 - Паспорт
 - Амьдрах байрны тодорхойлолт

- Гэмт хэрэгт холбогдоогүй тухай Цагдаагийн газрын тодорхойлолт (Цагдаагийн газрын тодорхойлолтыг Элчин сайдын яамаар дамжуулан авч болно)
- Фото зураг
- Цагдаагийн газар танаас нэмэлт материал шаардаж болно.
- 1000 КЅ-оос дээш хураамж
- Шийдвэр гаргах хугацаа нь 120 хоног болов ч энэ нь албан ёсны хугацаа биш болно.
- Визыг хамгийн ихдээ 1 жилийн хугацаагаар олгоно.
- Визыг Чех улсын нутаг дээр Гадаадын иргэдийн цагдаагийн газар өгсөн өргөдөлийн үндсэн дээр сунгаж болно. (жилд нэг удаа, гэхдээ энэ нь виз бус, харин хөдөлмөр эрхлэх зорилгоор удаан хугацаагаар оршин суух зөвшөөрлийг сунгуулж байгаа)

- Виз сунгах өргөдөлөө визны хугацаа дуусахаас 14-өөс доошгүй хоногийн өмнө гаргана.
- Чех улсад ирсэнээс хойш 3 хоногийн дотор Гадаадын иргэдийн цагдаагийн газар өөрийн оршин суух хаягаа бүртгүүлэх үүрэгтэй.
- Оршин суух хаягийн өөрчлөлтийг шилжин сууршихаасаа 30 хоногийн өмнө Гадаадын иргэдийн цагдаагийн газар мэдэгдэх үүрэгтэй.

!!! АЖИЛ ОЛГОГЧ ТАНЫГ АЖЛЫН ЗӨВШӨӨРӨЛГҮЙГЭЭР АЖИЛЛУУЛБАЛ ХОЮУЛАНД НЬ ШИЙТГЭЛ ОЛГОХ БӨГӨӨД ТОРГУУЛЬ ТӨЛҮҮЛНЭ. (АЖИЛ ЭРХЛЭГЧ НЬ 10 000 КЅ ХҮРТЭЛ, АЖИЛ ОЛГОГЧ НЬ 5 000 000 КЅ ХҮРТЭЛ) !!!

■ АЛБАДАН ГАРГАХ ШИЙДВЭР

- Гадаадын иргэдийн тухай хуулийн заалтуудыг зөрчвөл Гадаадын иргэдийн цагдаагийн газар таныг Чех улсын нутагт оршин суухыг хориглож албадан гаргана.
- Албадан гаргах шийдвэрийн эсрэг шийдвэр гарсанаас хойш 5 хоногийн дотор эсэргүүцэл бичиж болно.
- Хэрэв таны эсэргүүцлийг хүлээн авах боломжгүй гэвэл шийдвэр гарсанаас хойш 10 хоногийн дотор шүүхэд гомдол гаргаж болно.

ТА ӨӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУЛД,

- Хувийн баримт бичгүүд (паспорт, ажиллах зөвшөөрөл, удаан хугацаагаар болон байнга оршин суух эрхийн зөвшөөрөл гэх мэт)-ийг бусдад шилжүүлэхгүй байх, баримтуудынхаа хуулбарыг хийж аюулгүй газар хадгалах,
- Виз, оршин суух эрх, ажиллах зөвшөөрлөө сунгуулах ажлыг аль болох өөрөө гүйцэтгэх ,
- Хөдөлмөрийн Гэрээг ажил олгогчтой тогтмол байгуулах,
- Хөдөлмөрийн Гэрээг бичгээр үйлдэх хэрэгтэй бөгөөд Гэрээгүй ажиллах тохиолдолд цалин авах эрхтэй байх,
- Ажил олгогч таны эрүүл мэндийн болон нийгмийн даатгалыг төлж байгаа эсэхийг тодруулаарай. Энэ талаар Ажил олгогч нь хуулиар үүрэг хүлээсэн байдаг.

- Ажлаа өөрчлөхийг хүсвэл, та Чех улсын нутгаас гараад буцаж ирэх ёстой тул шаардлагатай мэдээллүүдийг сайн судалж, алдаа гаргахгүйн тулд өөр бусад хувилбаруудыг ч бэлтгэж тооцоорой.
- Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хөдөлмөр эрхлэлттэй холбогдолтой хууль дүрмүүдтэй танилцах хэрэгтэй бөгөөд энэ тухай мэдээллийг интернетийн www.portal.mpsv.cz/sz хаягаар англи, орос, украин болон бусад хэл дээр танилцах боломжтой.

БУСАД ШААРДЛАГАТАЙ МЭДЭЭЛЛҮҮД.

- Ажил олгогчтой хүндрэлтэй асуудал үүсээд байна уу (таны паспортыг хурааж авсан, тохиролцсон цалингаа олгохгүй байх, илүү цагаар ажиллахыг шаардан шахах, эмх замбараагүй эсвэл эрүүл мэнд, амь насанд халтай нөхцөлд ажиллуулах, таныг тогтмол хяналтын дор байлгах зэргээр) – тэгвэл орон нутгийн холбогдох хөдөлмөрийн байцаагчид хандаж болно (мэдээллийг **www.suip.cz** хаягаас олж болно)
- Дээрхи шалтгаануудаас болж ажил олгогчийн эсрэг гомдол гаргахыг хүсч байвал эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр (жишээ нь, хувийн эрх чөлөөг хязгаарласан, хаан боогдуулсан, хууран мэхэлсэн, дарласан, өөрийн саналаар бус гадаадад гаргасан, хүний наймаа эрхэлсэн гэх мэт шалтгаанаар) орон нутгийн цагдаагийн газарт хандаж, шалгуулах хүсэлт гаргаж

болно. Хэрвээ энэ мэдэгдлийн төлөө өөрийн амь нас, эрүүл мэндээр хохирохоос айж байвал таны талаар мэдээлэхгүй байхыг шаардах хэрэгтэй.

- Ажил олгогчын хөдөлмөрийн харьцааг зөрчсөн тухай гомдлыг 2 сарын дотор гаргана.
- Олгогдоогүй хөдөлмөрийн хөлсийг зөвхөн шүүхийн журмаар гаргуулдаг ба хуулийн ажиллагааны зардлыг нийт хохирогчид хуваан төлж болно. Хуулийн төлөөллийг Чех улсад өмгөөлөгчид гүйцэтгэдэг.
- Таныг ажилд зуучилсан зуучлагч нь танаас зуучлалын хөлс авах, эсвэл зуучлалын хөлсийг таны цалингаас суутган авахыг Чехийн хууль журмаар зөвшөөрдөггүй. Хэрэв ийм зүйл тохиолдвол Хөдөлмөр эрхлэлтийн газарт мэдэгдэнэ үү

- Хувийн баримт бичиг (паспорт)-аа үрэгдүүлсэн, хулгайд алдсан бол энэ тухайгаа яаралтай цагдаад мэдэгдэх хэрэгтэй. Цагдаагийн газар таныг бичиг баримтаа үрэгдүүлсэн эсвэл хулгайд алдсан тухай тодорхойлолт олгодог. Энэ тодорхойлолтын үндсэн дээр Засаг захиргааны байгууллагаас шинэ буюу орлох баримт олгогдоно.

ТАНЫ ХӨДӨЛМӨРИЙГ МӨЛЖИЖ БАЙНА УУ?

- Ажил олгогч таныг хууль бусаар халсан уу,
- Ажил олгогч таныг айлган сүрдүүлж байна уу,
- Таны бичиг баримтыг эсвэл хөдөлмөрийг хөлсийг хураан авсан уу,
- Хөдөлмөрийн хүнд хүчир нөхцөлд ажиллаж байна уу,
- Чөлөөтэй байж чадахгүй байна уу,
- Бичиг баримтгүй эсвэл бичиг баримтын хугацаа дууссан уу,

- Хаашаа хандахаа мэдэхгүй байна уу,
- Гэртээ буцахыг хүсч байна уу,
- Цагдаагийн болон Хөдөлмөр эрхлэлтийн газартай харьцахад тусламж хэрэгтэй байна уу,
- Хүнд байдалд ороод асуудлаа хэрхэн шийдэхээ мэдэхгүй байна уу,
- Дээрхи нөхцөлүүд нь таныг Чех улсын нутаг дээр хууль бусаар оршин суухад хүргэсэн үү,

ХЭРВЭЭ ТАНД ДЭЭРХИ НӨХЦӨЛҮҮДЭЭС ДОР ХАЯЖ 3 НЬ ТОХИОЛДСОН БОЛ ДООРХИ ХАЯГААР ХАНДАНА УУ

- **Прага хот дахь Ла Страда, Чех байгууллага,**
(La Strada ČR, o.p.s., Praha)
- Хүний наймааны золиос, хөдөлмөрийн мөлжлөгт өртсөн хүмүүст хуулийн зөвлөлгөө, нийгмийн халамж, эрүүл мэнд, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлнэ. Үйлчилгээ нь үнэ төлбөргүй бөгөөд таны тухай мэдээллийн нууцыг хадгална.
- **Холбогдох хаяг: утас 00 420/222 71 71 71**
(Мягмар, Пүрэв 10.00-16.00, Лхагва 12.00-18.00 ба 16.00-18.00 цагуудад орос хэлээр)

■ ЭНЭ ТАЛААРХИ ЗАРИМ БУСАД БАЙГУУЛЛАГУУД

- **Прага дахь Дүрвэгсдэд туслах байгууллага**
Гадаадын иргэдэд зөвлөлгөө өгөх ялангуяа дүрвэгсэдийн тухай асуудлаар – **00 420/284 683 714, www.opu.cz**
- **Прага дахь Интеграц ба Миграцийн Нөхөрлөл (Дүрвэгсдэд зөвлөлгөө өгөх Газар)**
Гадаадын иргэдэд дүрвэгчийн эрх авах болон бусад хүнд нөхцөл үүссэн үед зөвлөлгөө – **00 420/224 224 379, 00 420/605 253 994, www.uprchlici.cz**
- **Прага дахь Интеграцийн зөвлөлгөө**
Гадаадын иргэдэд урт хугацааны виз, урт хугацааны ба байнгын оршин суух виз, дүрвэгчийн өргөдөл гаргагч, дүрвэгсэдийн талаар зөвлөлгөө өгөх – **00 420/224 216 758, www.p-p-i.cz**

- **КМС-Усти над Лабем дахь Интеграцийн талаар зөвлөлгөө – 00 420/475 216 536, www.p-p-i.cz**
- **Прага дахь гадаадын иргэдийн интеграцийн төв**
Гадаадын иргэдэд урт хугацааны ба байнгын оршин суух визний асуудал, дүрвэгчийн өргөдөл гаргах, дүрвэгсэдийн талаар зөвлөлгөө өгөх – **00 420/ 222 713 332, www.cicpraha.org**
- **Прага дахь Олон улсын миграцийн байгууллага**
гадаадын иргэдэд эх орондоо буцахад нь туслах – **00 420/233 370 160, www.iom.cz**
- **Чехын католик буяны нийгэмлэг, Чех улсын хотууд**
Аюултай байдалд орсон гадаадынхан болон хүний наймааны золиос бологчдод туслах – **00 420/737 234 078 (non-stop), www.charita.cz**
- **Оломоуц дахь Цагаачидтай ажиллах иргэдийн нийгэмлэг**
00 420/585 242 535, www.soze.cz
- **Брно дахь Цагаачидтай ажиллах иргэдийн нийгэмлэг**
дүрвэгсэд ба бусад гадаадын иргэдэд туслах – **00 420/545 213 643, www.soze.cz**
- **Плзень дэх СОС-Арха – Диаконие төв**
Хүнд байдалд орсон хүн бүхэнд зориулагдсан – **00 420/377 223 221, archa.plzen@diakoniecse.cz**
- **Диаконие ЧСЭ – Мост дахь Нийгмийн тусламжийн цэг (Diakonie ĆSE – SSP, Most) – Хүнд байдалд орсон гадаадын иргэдэд зөвлөлгөө өгөх – 00 420/417 638 954, op.most@diakoniecse.cz**

- **Диаконие ЧСЭ – Рокычаны дахь Иргэдэд зөвлөлгөө өгөх цэг**
Хүнд байдалд орсон иргэдэд туслах –
00 420/775 720 492, 00 420/373 728 536,
op.rokycany@diakoniecce.cz

**ДЭЭРХИ БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛЧИЛГЭЭ
НЬ ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ!**

БУСАД ХЭРЭГЦЭЭТЭЙ ХАЯГУУД

- **http://portal.mpsv.cz/sz/zahr_zam** - гадаадын иргэдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой мэдээлэл, шаардлагатай хэвлэлийн материалуудыг энэхүү интернет хуудас болон Хөдөлмөр эрхлэлтийн газар, салбаруудаас –
00 420/221 921 111 (Прага хотын хөдөлмөр эрхлэлтийн газар) эсвэл үнэгүй утас **844 844 803** аас авна уу.
- **www.praceprocizince.cz** – Чех улсад ажил хайж байгаа гадаадын иргэдийн интернетийн портал хуудас
- **www.domavcr.cz** – Чех улсад амьдарч буй гадаадын иргэдийн эрх үүрэг, оршин суух эрх, ажиллах зөвшөөрөлтэй холбогдолтой болон бусад ашигтай мэдээллүүд

- **Гадаадын иргэдийн цагдаагийн газар** – лавлагааны утас – **00 420/974 841 356, 00 420/974 841 357,**
<http://www.policie.cz/sluzba-cizinecke-policie.aspx>

**!!! АЖИЛ ОЛГОГЧТОЙ ЭЛДЭВ МАРГААН ҮҮСЭЖ БОЛЗОШГҮЙ
ТУЛ ЧЕХ УЛСАД ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ
ӨӨРИЙН БИЧИГ БАРИМТУУДЫГ (АЖЛЫН ЗӨВШӨӨРӨЛ,
ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭ, ХҮЧИН ТӨГӨЛДӨР ПАСПОРТ ГЭХ МЭТ)
ХАДГАЛЖ БАЙХ НЬ ЧУХАЛ !!!**